НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

# ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ОЧИРБАТЫН НЯМБАТЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах чиглэлээр:** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагаанд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 1 | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 4 арга хэмжээний биелэлтийг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. Мөн “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт,үйл ажиллагааны хэрэгжилт, хүрсэн үр дүнгийн нэгтгэл (2015-2024)-ийг гаргаж тогтоосон хугацаанд тайлагнав. | 04-05 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 1.3.**<br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэг хамаарах 2 зорилтын 3 арга хэмжээний биелэлтийг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж тайлагнасан. | 05-06 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 1.4.**<br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамааран хэрэгжүүлэх, тайлагнах зорилт, арга хэмжээ байхгүй. | - | 100 |
| 5. | **Арга хэмжээ 1.5.**<br>Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор баталсан Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 93.3 хувиар үнэлэгдэж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт түвшингийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 04-06 | 100 |
| 6. | **Арга хэмжээ 1.6.**<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан.<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж ирээгүй болно. | 05-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | **Арга хэмжээ 1.7.**<br>Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 зорилтын 17 арга хэмжээний хэрэгжилт 58,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт түвшингийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | 04-06 | 100 |
| 8. | **Арга хэмжээ 1.8.**<br>Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд байгуулсан төрийн зарим чиг үүргийг 2025 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хүрээнд Нийслэлийн аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулаагүй болно. | - | 100 |
| **Зорилт 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон захирамжлалын баримт бичгийг бүртгэх, нэгтгэх, тайлагнах чиглэлээр:** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.**<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс байгууллагын чиг үүрэгт хамраарах заалтыг хяналтад бүртгэх, биелэлтийг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах<br>✓ Монгол Улсын хууль<br>✓ Улсын Их Хурлын тогтоол<br>✓ Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол<br>✓ Ерөнхийлөгчийн зарлиг<br>✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл<br>✓ Засгийн газрын тогтоол<br>✓ Ерөнхий сайдын захирамж<br>✓ Засгийн газрын хуралдааны | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайлангийн тоо | 12 | 6 | Байгууллагын чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 8 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн явцын биелэлтийг сар бүр гаргаж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 89,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэл<br>✓ Засгийн газрын албан даалгавар | | | | | | |
| 2. | **Арга хэмжээ 2.2.**<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын байгууллагын чиг үүрэгт хамаарах заалтыг бүртгэх, шилжүүлэх, биелэлтийг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийн тайлангийн тоо | 8 | 6 | Байгууллагын чиг үүрэгт хамаарах Нийслэлийн Засаг даргын 22 захирамж, Нийслэлийн Засаг даргын 1 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн 8 заалт байгууллагын хяналтад бүртгэж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 81,1 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 98,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан.<br>Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Ажлын сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж тайлагнасан. | 01-06 | 100 |
| **Зорилт 3. Хариуцлагын гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, тайлагнах чиглэлээр:** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.**<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас байгууллагын удирдлагатай байгуулах 2025 оны “Хариуцлагын гэрээ”-ний төслийг боловсруулж батлуулах | Батлуулсан гэрээний тоо | 1 | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас газрын даргатай байгуулах 2025 оны “Хариуцлагын гэрээ”-г Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, | 01-03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хүнд суртал, чирэгдэлгүй ажиллах зэрэг 6 бүлэг 44 заалтаар боловсруулан батлуулсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** “Хариуцлагын гэрээ”-ээр байгууллагын удирдах ажилтны хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах | Батлуулсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргатай 2025 онд байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг 3 зорилтын 28 заалтаар боловсруулж батлуулсан. | 02-03 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 3.3.** “Хариуцлагын гэрээ”-ээр байгууллагын удирдах ажилтны хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас газрын даргатай байгуулсан 2025 оны “Хариуцлагын гэрээ”-ний биелэлтийг хангах үйл ажиллагааны 28 заалт бүхий арга хэмжээний төлөвлөгөөг биелэлт 2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 89,5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлж тайлагнасан. | 05-06 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 3.4.** Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Батлуулсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 11 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж батлуулсан. | 02-03 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 3.5.** Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэх тогтоосон хугацаанд тайлагнах | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 1 | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 78.4%-ийн биелэлттэй, тайланг тогтоосон хугацаанд | 05-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлж тайлагнасан. | | |
| **Зорилт 4. Дүрмээр хүлээсэн үүрэг, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах чиглэлээр:** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг нэгтгэх, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 4 | 2 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмээр хүлээсэн үндсэн 15 чиг үүргийн хэрэгжилтийг улирал бүр гаргаж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 74.0 хувийн биелэлттэй хэрэгжиж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн тайлагнан ажилласан. | 03-06 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 4.2.** Байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 12 | 6 | Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг сар бүр боловсруулан гаргаж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлж тайлагнасан. | 01-06 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 4.3.** Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны эхний хагас жил, жилийн тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны эхний хагас жилийн тайланг нэгтгэн гаргаж тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлж тайлагнасан. | 06 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 4.4.** Байгууллагаас 2025 онд шинээр санаачилсан, шинэлэг ажлын тайланг гарган тогтоосон хугацаанд тайлагнах | Тайлагнасан баримт бичгийн тоо | 1 | - | Хөгжлийн бодлогын баримт бичгүүд, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлж тайлагнасан. | 06 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 4.5.** Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан батлуулах, тайланг нэгтгэх, тогтоосон хугацаанд | Тайлагнасан баримт бичгийн тоо | 2 | 1 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилтын 22 заалтаар боловсруулж батлуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг | 03-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнах | | | | даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн тайлагнан ажилласан. | | |
| **Зорилт 5.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 5.1.**<br>Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, заавар, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэх | Шийдвэрлэлтийн хувь | 90% | 95% | “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, албан хэрэг хөтлөлтөд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу баримт бичгийг хөтөлж, албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой шилжиж ирсэн хариутай 2 албан бичиг, хариугүй 20 албан бичиг нийт 22 албан бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэж, 10 албан бичгийг холбогдох журам, стандартын дагуу боловсруулж явуулсан.<br>Албан бичгийн шийдвэрлэлт 100 хувь, 6.05 үзүүлэлттэй, зөрчил тооцогдсон, хугацаа хоцроож шийдвэрлэсэн албан бичиг байхгүй. | 01-06 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 5.2.**<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгөх | Хадгаламжийн нэгжийн тоо | 10 | 10 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны цаасан суурьт байнга хадгалах 11, түр хадгалах 5 нийт 16 архивын хадгаламжийн нэгж үүсгэн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. | 01-05 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 5.3.**<br>Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар өгсөн үүрэг даалгавар бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газар, хэлтсийн дарга болон газрын хурлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтээс албан тушаалын чиг үүрэгт хамаарах үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн хэрэгжүүлж, цаг хугацаанд нь тайлагнасан. | 01-06 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийнхувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үндсэн чиг үүргийн хүрээнд зохион байгуулах эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оролцох | Оролцсон эвент, үзэсгэлэн арга хэмжээнийй тоо | 3 | 3 | Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, "УБ фүүд фестиваль Узбек улсын хоолны өдөрлөг”, “Талын салхи” олон улсын мото наадам зэрэг 4 арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хариуцсан ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэв. | 01-06 | 100 |
| 2. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.** Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг гаргаж тайлагнах | Шуурхай биелэлтийг тайлагнах | 5 | 6 | Нийслэлийн удирдах ажилтнуудын 11 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 31 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн хангаж хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн тайлагнан ажилласан. | 03-06 | 100 |
| 3. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.** “Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн хуваарилагдсан дүүрэгт ажиллах | Тайлагнасан илтгэх хуудсын тоо | - | 1 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай | 01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | штабын даргын баталсан “Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудад пийшин зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгчийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэх, түүхий нүүрс ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа гаргах, зөвлөгөө зөвлөмж хүргэх хяналт шалгалтын ажлаар 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд ажиллаж, нийт 675 өрхөөс судалгаа авах ажлыг хамтран зохион байгууллаа. | | |
| 4. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.** Эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах ажлын хүрээнд хуваарилагдсан дүүрэгт ажиллах | Тайлагнасан илтгэх хуудсын тоо | - | 1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын баталсан хуваарийн дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах ажлыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллагуудтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгууллаа.Чингэлтэй дүүргийн менежер, мэргэжлийн байгууллагуудын өгсөн чиглэлийн хүрээнд эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах ажил 11 байгууллагын 147 ажилтан, албан хаагчид хамтран зохион байгуулав. | 04 | 100 |
| 5. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.** Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн үзүүлэлтийн мэдээллийг оруулах | Мэдээлэл оруулсан хугацаа | - | 06.20 | Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хүрээнд Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүлгийн 18 үзүүлэлтийн мэдээллийг бүрэн http://www.frontoffice-dev.shilen.gov.mn/ веб сайтад байршуулсан. | 06 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Хариуцсан чиглэлийн хүрээнд сургалт, семинарт, зөвлөгөөнд хамрагдаж тухай бүр мэдлэг чадвараа дээшлүүлнэ. | Хамрагдсан сургалтын тоо | 8 | 3 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын танилцуулах сургалт, ХАСХОМ бөглөх албан хаагчдад зориулсан сургалт, ISO стандарт нэгдсэн сургалт, Монгол бичгийн сургалт зэрэг 3 сургалт, зөвлөн чиглүүлэх менторшип хөтөлбөр, Төрийн албаны манлайлал зөвлөгөөнд оролцсон. | 01-06 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 3.** Солонгос хэлний сургалтад хамрагдаж хэлний мэдлэг чадвараа дээшлүүлнэ. | Цаг | - | 144 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Койка” олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй Солонгос хэлний сургалтад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор хамрагдаж 7 хоног бүрийн 1, 3 дахь өдрүүдэд сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлсэн. | 01-04 | 80 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН НЯМБАТ

2025 оны 06 дугаар сарын 20